

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
2015 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**



МӨНГӨ, БАНК, ДААТГАЛ

2015 оны эхний 11 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 7210,3 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 478,3 сая төгрөгөөр буюу 9,3 хувиар өссөн байна. 2015 оны эхний 11 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Эрдэнэцогт, Жаргалант, Богд, Баянлиг, Өлзийт, Баацагаан, Бууцагаан, Шинэжинст, Заг сумууд биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТатвар 130,7 сая төгрөг, ашигт малтмал 57,2 сая төгрөг, ЦХТА орлого 414,0 сая төгрөг, АТӨЯХ-н татвар 21,6 сая төгрөг, ҮХЭХ-н татвар 20,2 сая төгрөг, газрын төлбөр 32,2 сая төгрөг, ИОТТХ 45,5 сая төгрөг, патент 7,1 сая төгрөг, хог хаягдлын хураамж 49,8 сая төгрөг, нохойн татвар 1,8 сая төгрөг, бууны татвар 1,6 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 11,6 сая төгрөг, газрын дуудлага худалдаа 58,1 сая төгрөг, түгээмэл тархацтай АМАТ 24,1 сая төгрөг, газрын тосны төлбөр 20,3 сая төгрөг, ус ашигласны төлбөр 276,8 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны 20,1 сая төгрөгөөр тус тус тасарч бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 2,4 хувь, нэмүү өртгийн албан татвар 6.1 хувь, ЦХТА орлого 53,8 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 4.4 хувь, хүү торгууль 7,1 хувь бусад төлбөр хураамж 26,2 хувийг эзэлж байна.

2015 оны 11 дүгээр сарын эцэст иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 46629,7 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 119092,3 сая төгрөгт хүрчээ. Чанаргүй зээл 1393,8 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1,1 хувийг эзэлж байна.



ЭРҮҮЛ МЭНД

2015 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд 1957 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 66 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 84,4 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын эмнэлэгт 3.8 хувь, 11,8 хувь нь сумын эмнэлэгт төрж, Бууцагаан, Баянлиг, Баянцагаан, Гурванбулаг сум, Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвд гэрийн төрөлтийн тохиолдол бүртгэгдэж, нийт төрөлтөд гэрийн төрөлтийн эзлэх хувь 0.36 байна.

Нийт амьд төрсөн 1962 хүүхдийн 5 нь ихэрлэж, нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд эхний 11 сарын байдлаар 14,8 байна.

Эхний 11 сарын байдлаар архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салхин цэцэг 99, тэмбүү 74, арьсны мөөгөнцөр 7, бруцеллээс 2, сүрьеэ 9, суулгалт халдвар 10 тохиолдлоор өссөн бол трихоминиаз 2, гар хөл амны өвчин 4, гахайн хавдар 1 тохиолдлоор тус тус буурсан байна.

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар нас баралтын 434 тохиолдол бүртгэгдсэний 26,5 хувь нь эмнэлэгт нас барснаас 8,8 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна.

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны эхний 11 сард 14372 байсан бол энэ оны эхний 11 сарын байдлаар 13020 болж 1352 дуудлага буюу 9,0 хувиар буурсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

2015 оны эхний 11 сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 4271111 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 88416 мянган төгрөгөөр буюу 9,8 хувиар өсчээ.

Эхний 11 сарын байдлаар аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзэхэд урьд оны мөн үеэс нарийн боов 19.1 тн-оор, талх 38.1 тн-оор, хоормог 4.6 мян.литр, түгээсэн цэвэр ус 42.7 мян.м3-ээр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

	Арваннэгдүгээр сар		
	2014	2015	2015.11/2014.11
Нийт борлуулалт	4182695.0	4271111.0	102.1

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Арваннэгдүгээр сар		
		2014	2015	2015.11/2014.11
Тараг	Мян.л	3.3	4.1	124.2
Хоормог	Мян.л	2.6	7,2	276.9
Нарийн боов	тн	52.8	71,9	136.2
Талх	тн	73.6	111.7	151.8
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	213.7	256.4	119.9



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

2015 оны эхний 11 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 19489,6 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 4069,9 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1642,9 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 383,8 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 41,4 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 849,8 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 217,3 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 58,1 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 19,9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 207,0 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 3007,9 сая төгрөг, рашаан сувиллын зардалд 620,0 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 329,8 сая төгрөг тус тус олгожээ.



ГЭМТ ХЭРЭГ

2015 оны эхний 11 сард аймгийн хэмжээнд нийт 326 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 83 нэгжээр буюу 20.3 хувиар буурсан. Хэргийн илрүүлэлт 71.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.2 пунктээр буурсан. Хэргийн гаралт 12 суманд буурч, 6 суманд өсөж, 2 суманд ижил түвшинд байна. Гэмт хэрэгт 356 хүн холбогдон шалгагдсан ба үүнээс 14-17 насны 29, 18-с дээш насны 327 хүн байна. Гэмт хэргийн улмаас 344 иргэн хохирч 11 хүн нас барж, 160 хүн гэмтсэн байна. 446,1 сая төгрөгийн хохирол учирснаас 274,7 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 61,6 хувьтай байна.

Хүнийг санаатай алах гэмт хэрэг 5 нэгжээр буюу 83.3 хувь, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 8 нэгжээр буюу 6,3 хувь, хүчин 4 нэгжээр буюу 36,3 хувь, өмчийн хулгай 7 нэгжээр буюу 5,8 хувь, иргэдийн өмчийн хулгай 11 нэгжээр буюу 13,4 хувь, танхай 10 нэгжээр буюу 55,5 хувь, бусад гэмт хэрэг 20 нэгжээр буюу 30,3 хувь, насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 17 нэгжээр буюу 37 хувь тус тус буурсан байна.

Харин малын хулгай 4 нэгжээр буюу 14,3 хувь, дээрэм 3 нэгжээр тус тус өссөн байна.



ҮНЭ ТАРИФ

Нийслэл, бүс, аймгийн төв, сум, дүүргийн өмнөд талын тусгай зориулалтын газруудад, 11 жилийн туршид, үйлчилгээний үнэ өөрчлөлт

percentage

Ламдал Төрөл	Өмнөх Үнэ	Нэвтрүүлэх Үнэ	Өөрчлөлт Хүрээ, %	Нийслэл Төв	Бүс Төв	Аймаг, нийслэл Төв	Сүм, дүүргийн Төв	Сүм, дүүргийн Төв	Нийслэл Төв	Ламдал Төрөл	Зориулалтын Төрөл	Өөрчлөлт Хүрээ, %	Зориулалтын Төрөл
Баянхонгор	174.6	149.1	229.4	232.8	142.6	258.3	124.1	138.1	92.7	81.8	240.0	198.6	150.8

Нийслэл, бүс, аймгийн төв, сум, дүүргийн өмнөд талын тусгай зориулалтын газруудад, 11 жилийн туршид, үйлчилгээний үнэ өөрчлөлт

percentage

Ламдал Төрөл	Өмнөх Үнэ	Нэвтрүүлэх Үнэ	Өөрчлөлт Хүрээ, %	Нийслэл Төв	Бүс Төв	Аймаг, нийслэл Төв	Сүм, дүүргийн Төв	Сүм, дүүргийн Төв	Нийслэл Төв	Ламдал Төрөл	Зориулалтын Төрөл	Өөрчлөлт Хүрээ, %	Зориулалтын Төрөл
Баянхонгор	108.0	97.6	108.8	117.9	106.0	110.9	106.0	107.1	97.5	100.0	104.3	100.0	110.9

Нийслэл, бүс, аймгийн төв, сум, дүүргийн өмнөд талын тусгай зориулалтын газруудад, 11 жилийн туршид, үйлчилгээний үнэ өөрчлөлт

percentage

Ламдал Төрөл	Өмнөх Үнэ	Нэвтрүүлэх Үнэ	Өөрчлөлт Хүрээ, %	Нийслэл Төв	Бүс Төв	Аймаг, нийслэл Төв	Сүм, дүүргийн Төв	Сүм, дүүргийн Төв	Нийслэл Төв	Ламдал Төрөл	Зориулалтын Төрөл	Өөрчлөлт Хүрээ, %	Зориулалтын Төрөл
Баянхонгор	106.5	97.4	108.8	112.6	105.9	110.9	106.0	107.1	97.5	100.0	104.3	100.0	110.9

Нэгдүгээр сарын 1-н өдөр, 11 сарын 1-н өдөр, 11 сарын 1-н өдөр

percentage

Лайгуулагч	Хүний нөөц	НАА	Төрийн өмчийн хөрөнгийн өртөг	Нийслэл	Лайгуулагч	Хүний нөөц	Хүний нөөц	С	Н	Л	З	З
Баянхонгор	99.9	98.5	100.0	101.5	96.6	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС